



“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СУЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

ЭРДЭНЭТ, БУЛГАН, ХЯЛГАНАТ ДЭД СТАНЦУУДЫН ОПУ, ЗРУ, АВТОГРАЖ, ДУЛААНЫ
ШУГАМ, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН БОЛОН ҮҮДНИЙ ХЭСЭГ, АХЛАХ ИНЖЕНЕРИЙН
ӨРӨӨНИЙ БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендерийн нэр: **Булган дэд станцын авто граж, 10кВ-ын ЗРУ-ын дээврийн засвар
Хялганат дэд станцын ОПУ, ЗРУ-ийн барилга, дээврийн засвар
Эрдэнэт дэд станцад чийрэгжүүлэлтийн болон ахлах инженерийн
өрөө, үүдний хэсэг, дулааны шугам засварлах**

Тендерийн дугаар: **ЦДУС/202001012**

Эрдэнэт хот.
2020 он

ҮННИЙ САНАЛ АВАХ УРИЛГА

2020 оны 04-р сарын 17.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК –ийн Хангайн бүсийн салбар сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “**Эрдэнэт, Булган, Хялганат дэд станцуудын ОПУ, ЗРУ, автограф, дулааны шугам, чийрэгжүүлэлтийн болон үүдний хэсэг, ахлах инженерийн өрөөны барилгын их засварын ажил**” гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 30.000 /гучин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 12.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 12:10 цагт тендерийг цахимаар нээнэ.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Орхон аймаг Баян-Өндөр сум Баянцагаан баг

ЦДҮС ТӨХК-ийн Хангайн бүсийн салбарын

төв оффисийн 205 тоот.

Утас: 70396054 Факс: 976-70396054

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцгчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарыт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлгдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн

бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцгчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцог залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| ТОӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ | Шалгуур үзүүлэлт |
|-----------------------|---|
| ТОӨЗ 1.1 | <ul style="list-style-type: none"> - Унийн санал бэлдэхдээ тендерийн жишиг маягтын дагуу ирүүлнэ. - Сүүлийн 1 жилийн буюу 2019 оны санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/; - Сүүлийн 2 жилийн ижил төстэй ажил хийж гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл - Нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт - Шүүхийн тодорхойлолт - Харилцагч банкны тодорхойлолт - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар - Компанийн дэлгэрэнгүй танилцуулга - Ажил гүйцэтгэх нарийвчилсан хуваарь гаргаж, төлөөлөх эрх бүхий этгээд баталгаажуулж ирүүлнэ. - Ажлын тоо хэмжээний дагуу Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдэж буй норм дүрмийн дагуу төсөв зохиох программаар Төсөв хийж баталгаажуулан ирүүлнэ. - Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. - Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /PDF/ шилжүүлж ирүүлэх ба тод гаргацтай байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно. - Тендер нээсэн өдрийн байдлаар аливаа төрлийн татварын өр, төлбөргүй байна. <p>Үүнд: Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл: /баталгаажуулах/</p> <p>2.1.1 /Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт/, 2.1.2 /Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил /, 2.2.1 /Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна самбар шугам сүлжээний угсралт/ 2.2.2 /Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, холбоо дохиолол, интернэт сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт/</p> <p>-тусгай зөвшөөрлийн шаардлагын дагуу үндсэн тоног төхөөрөмж машин механизмтай байна.</p> <p>Жич: Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p> |
| ТОӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Орхон аймаг ЦДУС ТӨХК-ийн Хангайн бүсийн салбарын төв байранд Огноо: Тендерийг 2020 оны 04 дүгээр сарын 24-ны Цаг: 12 цаг 00 минут.</p> |
| ТОӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Орхон аймаг ЦДУС ТӨХК-ийн Хангайн бүсийн салбарын төв байранд Огноо: Тендерийг 2020 оны 04 дүгээр сарын 24-ны Цаг: 12 цаг 10 минут.</p> |
| ТОӨЗ 6.2 | Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаараас бүрдэнэ: |

| | |
|--|---|
| | <p>Булган дэд станцын авто граж, 10кВ-ын ЗРУ-ын дээврийн засвар Хялганат дэд станцын ОПУ, ЗРУ-ийн барилга, дээврийн засвар Эрдэнэт дэд станцад чийрэгжүүлэлтийн болон ахлах инженерийн өрөө, үүдний хэсэг, дулааны шугам засварлах”</p> <p>Тендер шалгаруулалтын дугаар: ЦДҮС/202001012</p> |
|--|---|

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Техникийн тодорхойлолтыг бэлтгэх санамж

Товч бөгөөд тодорхой бэлтгэгдсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.

Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ өрсөлдөөнийг аль болох өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд үүний зэрэгцээ худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн, эсхүл орчин үеийн загварын, зураг төсөл, материалын хувьд сүүлийн үеийн хандлагыг хангасан байх нөхцөлийг техникийн тодорхойлолтод шаардах ёстой.

Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай байдаг. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ метрийн системийг ашиглана. Бүх салбарт хэрэглэж болох нийтлэг жишиг техникийн тодорхойлолт гэж байхгүй. Бүх төрлийн бараа, ажлын стандарт буюу ерөнхий техникийн тодорхойлолт боловсруулж стандартчилах нь чухал ач холбогдолтой. Энэ стандарт техникийн тодорхойлолтыг тухайн ижил бараанд нийцүүлэн, зохих өөрчлөлт оруулах замаар ашиглана.

Авто зам, усан зогсоол, төмөр зам, орон сууц, усжуулалт, усан хангамж гэх зэрэг дэд бүтцийн салбаруудад тухайн бүс нутгийн ижил төстэй нөхцөлд давтагдаж хийгдэх ажлуудад стандарт ерөнхий техникийн тодорхойлолтыг хэрэглэх нь ихээхэн давуу талтай. Хэдийгээр тухайлсан ажлын гэрээнд заавал хэрэглэх шаардлагагүй хэдий ч барилгын ажилд хамаарах онцлог шинж чанар, материал, тоног төхөөрөмжийн бүх ангиллыг ерөнхий техникийн тодорхойлолтод тусгах шаардлагатай. Тухайн ажлын техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ ерөнхий техникийн тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт хийх буюу шаардлагагүй зүйлийг түүнээс хасна.

Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Бараа, материал, шинж чанарын талаарх техникийн тодорхойлолтын стандартад аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа, материал, шинж чанар нь энэ стандартыг хангах буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй. Дараах заалтыг гэрээний тусгай нөхцөлд, эсхүл техникийн тодорхойлолтод тусгаж болно.

Жишиг заалт: Стандарт болон кодын дүйцэх байдал

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал болон хийгдэх, эсхүл турших ажлын стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ.

Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй жишигчүйц, эсхүл түүнээс илүү чанартай бусад стандарт, кодыг төслийн менежер хянаж, бичгээр зөвшөөрөл олгосон бол хүлээн зөвшөөрнө.

Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд зориулсан эдгээр санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно.

Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулах шаардлагагүй.

БАТЛАВ:
ЦДУС ТӨХК -ИЙН ТЭРГҮҮН ДӨД ЗАХИРАЛ БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР:
Б. ДАШДАВАА

Техникийн тодорхойлолт

ЦДУС ТӨХК ХБС-ын Булган дэд станцын автограж, хаалттай хувиарлах
байгууламжийн барилга дээврийн засварын ажлын техникийн тодорхойлолт
№4

| Д/Д | Хийгдэх ажлын дэс дараалал | Хэмжих нэгж | Тоо ширхэг |
|-------------------------------------|---|-------------|------------|
| 1 | ХХБ-ийн дээврийн раам /яс мод зангидах | м2 | 102.4 |
| 2 | ХХБ-ийн дээврийг төмөрлөх | м2 | 102.4 |
| 3 | Усны хаялга хийх | м | 25 |
| 4 | Налишка хийх / ХХБ-ийн дээвэрт хүрээ хийх / | м | 25 |
| 5 | Будгийн ажил / ХХБ-ийн дээврийн хүрээ, баадан / | м2 | 5 |
| Автогражийн дээврийн засварт | | | |
| 1 | Автогражийн дээвэр төмөрлөх | м2 | 20 |
| 2 | Автогражид led гэрэлтуүлэг тавих | ш | 6 |
| 3 | Автогражид цахилгаан монтаж хийх /Гэрэлтүүлгийн монтажны утас 2*2.5мм-тэй зэс, Халаагуурын монтажны утас 2*4 мм хөндлөн огтлолтой зэс дамжуулагч утас байна / | м | 55 |
| 4 | Автогражид усан паартай цахилгаан халаалт хийх | ш | 3 |
| 5 | Автогражид онгорхой нүх, завсраар хөөс шахах | ш | 10 |
| 6 | Автогражийн таазанд 5см зузаантай хөөсөнцөр хавтангаар дулаалга хийх | м2 | 36 |
| 7 | Автогражийн таазанд доторлогооны хавтан хадах | м2 | 36 |

Тавигдах шаардлага:

Барилгын ажлыг гүйцэтгэхдээ БНБДүрмийн норм дүрэм, стандарт, холбогдох бусад журмын заалтыг мөрдлөг болгоно.

Барилгыг чанартай материалаар чанарын өндөр түвшинд технологийн дагуу, чанарын гологдолгүй хийж гүйцэтгэнэ.

Бүх материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн эсхүл орчин үеийн загварын сүүлийн үеийн хандлагыг хангасан байна.

Ажлыг гэрээт хугацаандаа чанарын шаардлагыг хангаж, бүрэн гүйцэтгэх.

Хянасан: ХБС-ын Ерөнхий инженер

Б.Анхбаяр

Гүйцэтгэсэн:
Булган дэд станцын ашиглалтын инженер

Б.Батцогоо – 2

БАТЛАВ:

ЦДУС ТӨХК –ИЙН ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР: 
Б. ДАШДАВАА

1115103400442305221

Техникийн тодорхойлолт

ЦДУС ТӨХК ХБС-ын Эрдэнэт дэд станцын чийрэгжүүлэлтийн өрөө болон
ахлах инженерийн өрөө, үүдний хэсэг, дулааны шугамын засварын ажлын
техникийн тодорхойлолт №5

| Д/Д | Хийгдэх ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо ширхэг |
|--|---|-------------|------------|
| 1. Диспетчерийн байрны үүдний хэсэг | | | |
| 1 | Удирдах щитний байрны үүдэн хэсгийн хаалга буулгах | м2 | 1.9 |
| | Удирдах щитний байрны үүдэн хэсгийн хаалга байсан хэсгийг битүүлж өрөх | м2 | 2 |
| | Аккумуляторын өрөөний ханыг хаалганы хэмжээнд нүхлэх, хаалга гаргах | м2 | 2 |
| | Шинээр вакум хаалга хийх | м2 | 1.9 |
| | Хаалганд амалгаа хийх | м2 | 2 |
| | Дулааны шугамын нүхтэй хэсгийг бөглөж, таглаа хийх | м2 | 1.5 |
| | Удирдах щитний байрны үүдэн хэсгийг хулдааслах | м2 | 30 |
| 1 | Удирдах щитний байрны үүдэн хэсгийн ханыг өнгөт хавтангаар бүрж засварлах | м2 | 45 |
| | Унтраалга, цахилгаан монтажыг солих | ш | 5 |
| | "00", Холбоо, аккумуляторын өрөөний хаалганууд будах | м2 | 6 |
| | Үүдний өрөөнд цахилгаан монтаж хийж гэрэлтүүлэг тавих | м | 15 |
| | Үүдний хэсгийн өрөөнд хаалга сууринуулах | м2 | 1.9 |
| | Үүдний хэсгийн өрөөнд 25-н хана өрөх | м2 | 4 |
| | Үүдний хэсгийн жижиг өрөө, коридорт лампиран тааз хийх | м2 | 25 |
| | ОПУ-н гадна үүдний хэсгийн талбайд сандал сууринуулах | ш | 2 |
| | ОПУ-н гадна үүдний хэсгийн талбайг цементлэн тэгшлэх | м2 | 18.5 |
| | Гадна үүдний хэсгийн талбайд босоо гэрэлтүүлэг тавих | ком | 10 |
| 2. Дулааны шугам | | | |
| 2 | ОПУ-н халаалтыг нэгдсэн халаалтаас тусгаарлах сантехникийн холболтыг өөрчилж, монтажлах | ком | 1 |
| | 2 хэсэг онгойх /150*190*2/ раам зангидах нугас хийх | м2 | 6 |
| | 2 хэсэг онгойх /150*190*2/ раамны ар талыг бөглөх | м2 | 6 |
| | 2 хажуу хэсгийн хаалт хийж бөглөх /60*190*2/ | м2 | 2.3 |
| | Раамны доор дугуй сууринуулах | ш | 4 |
| | Онгойх хэсгүүдийн дотор талд 2 хэсэгт хувааж тавиур бэлдэх | м2 | 2 |
| 3. Чийрэгжүүлэлтийн өрөө | | | |

| | | | |
|--|--|----|------|
| | Засварын хойд өрөөний хана буулгах, тэгшлэх | m2 | 120 |
| | Засварын хойд өрөөний хана таазыг засварлах | m2 | 92 |
| | Хана өрж битүүлэх | m2 | 24 |
| 3 | Ханыг шавардаж, замаскадах | m2 | 120 |
| | Ханыг зүлгүүрдэж, будах, | m2 | 120 |
| | Өрөөнд паркетин шал хийх | m2 | 92 |
| | Шинээр лампирэн тааз хийх | m2 | 92 |
| | Амралтын өрөөний хананд шинээр обой наах | m2 | 48 |
| 4. Ахлах инженерийн болон холбооны өрөө | | | |
| | Холбооны өрөөнд серверийн зориулалттай хөндий шал хийх /F1250, 600*600*32мм/ кальци сульфат материалыаар хийгдсэн даац 568кг, ус болон галын хамгаалалттай, хөлний өндөр 10-15см, тооцох нэгж кв.м | m2 | 20 |
| | Холбооны өрөөний ханын ил хэсгийг өнгөт хавтангаар бүрж үлдсэн хэсгийг замаскадаж эмульсдэх | m2 | 20 |
| | Холбооны өрөөний паарны наагуур хаалт хийх | ш | 1 |
| | Холбооны өрөөнд шинээр хаалга суулгах | m2 | 1.9 |
| | Аккумляторын өрөөнд 25-н хана /276*300/ өрж тусгаарлан вакуум хаалга хийх, раам зангидах дээвэрлэх | m2 | 8.3 |
| 4 | Аккумляторын өрөөний ашиглагддагүй дээд агааржуулалтын хоолойг буулгах, үлдсэн хоолойнд /F40/ агааржуулагч сэнс тавих | м | 10.6 |
| | Аккумляторын өрөөний хананыг эмульсдэх будах | m2 | 47.4 |
| | Ахлах инженерийн өрөөний ханыг өнгөт хавтангаар бүрж /150*1400/ үлдсэн хэсгийг замаскадаж эмульсдэх | m2 | 48.4 |
| | Ахлах инженерийн өрөөний холбоо, мотор генераторын шитийг жижигруулж монтажлах, шит солих | ш | 1 |
| | Ахлах инженерийн өрөөний паарны наагуур хаалт хийх | ш | 1 |
| | 4ш паар тавьж сангийн холболтууд хийх | m2 | 20 |
| | Цахилгааны доторх монтаж хийх | m2 | 6 |
| | Диспетчериин хяналтын дэлгэцийн суурь хийж байрлуулах өндөр нь-340*200, суурь хэсэг 30*340 | m2 | 11 |
| | Барилгын дээврийн усны хаялага хийх | m2 | 3.6 |

Тавигдах шаардлага:

Барилгын ажлыг гүйцэтгэхдээ БНБДүрмийн норм, дүрэм холбогдох бусад журмын заалтыг мөрдлөг болгоно.

Барилгыг чанартай материалыаар чанарын өндөр түвшинд технологийн дагуу, чанарын гологдолгүй хийж гүйцэтгэнэ.

Бүх материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн эсхүл орчин үеийн загварын сүүлийн үеийн хандлагыг хангасан байна.

Ажлыг гэрээт хугацаандаа чанарын шаардлагыг хангаж, бүрэн гүйцэтгэх.

Хянасан: ХБС-ын Ерөнхий инженер

Б.Анхбаяр

Гүйцэтгэсэн:

АШҮА-ны ахлах инженер

Б.Энхтуяа

УДАЛЫГАТААР СОХ

БАТЛАВ:

ЦДҮС ТӨХК -ИЙН ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР: *Б. ДАШДАВАА*
ХУЧИРЫН СУМЧАР
ЦДҮС

1115405450-242685231

Техникийн тодорхойлолт

ЦДҮС ТӨХК ХБС-ын Хялганат дэд станцын удирдах байр / ОПУ /,
хаалттай хувиарлах байгууламж / ЗРУ /-гийн барилга дээврийн
засварын ажлын техникийн тодорхойлолт №6

| Д/Д | Хийгдэх ажлын дэс дараалал | Хэмжих нэгж | Тоо ширхэг |
|---------------------------|---|-------------|------------|
| 1. ОПУ-гийн засвар | | | |
| 1 | Удирдах щитний хана тааз засварлах | м2 | 77 |
| | Удирдах щитний хана таазны шаварын засвар хийх | м2 | 77 |
| | Хананы шавар нурсан, будаг хуурсан болон хөндийрсөн хэсгийг хусч, цэвэрлэгээ хийх | м2 | 77 |
| | Удирдах щитний хана, таазанд замаска татах, эмульсдэх | м2 | 77 |
| | Удирдах щитний хэсэгт паркетин шал хийх | м2 | 77 |
| | Хана буулгах, тэгшлэх | м2 | 10 |
| | Ханыг шавардаж, замаскадах | м2 | 10 |
| | Ханыг зүлгүүрдэж, будах, | м2 | 10 |
| | Цонхны нүх гаргаж хана цоолох | м2 | 3 |
| | Цонх суурилуулах | м2 | 3 |
| | Цонхны тавцан хийж, амалгаа хийх | м2 | 3 |
| | Хөшиг хийх | м2 | 5 |
| | Дүүжин тааз шинээр хийх | м2 | 15 |
| | Эко халаагуур тавих | ш | 8 |
| 2 | ОПУ-н үүдний гадна хаалга шинээр солих | м2 | 1.6 |
| | ОПУ-н үүдний гадна хэсэгт тамбур хийх | м2 | 6 |
| | ОПУ-н үүдний гадна хэсэгийн тамбурт дээвэр хийх | м2 | 7 |
| | 2. ЗРУ-гийн засвар | | |
| | 10кВ-ын ХХБ-ын өрөөний хана таазыг засварлах | м2 | 119 |
| | ОПУ-с ЗРУ-руу орох хаалга шинээр солих | м2 | 1.6 |
| | Шал нийтэд нь будах, аюулгүйн зураас хийх | м2 | 119 |
| | Гэрэлтуулэгийн щит угсрал, розетка, унтраалга солих | ш | 10 |
| | Цахилгаан монтажыг бүрэн солих /кабель утас/ | м | 300 |
| | Цахилгаан халаагуурын цахилгааны монтаж шинээр угсрал / 2*4мм / | м | 50 |
| | Монтажийг далдлах | м | 300 |
| | Эко халаагуур тавих | ш | 8 |

3. Дээврийн засвар

| | | | |
|---|--|----|-----|
| 3 | Хуучин дээвэр хуулах | m2 | 196 |
| | Хайлмал материалан дээвэр буулгах | m2 | 196 |
| | Дээврийн талбайд цементэн тэгшилгээг засварлах | m2 | 196 |
| | Дээвэрт хөржүүлэлт түрхлэг хийх | m2 | 196 |
| | Дээврийн нийт талбайд 1 үе хар цаас наах | m2 | 196 |
| | Дээврийн нийт талбайд 2 үе хар цаас наах | m2 | 196 |
| | Дээврийн борооны усны хаялага хийх | m2 | 35 |
| | Барилгын ханыг будах | m2 | 196 |
| | Барилгын дотор тааз эмульсдэх | m2 | 196 |
| | Барилгын ханын хөндийрсөн шавар будгийг хусаж, тэгшлэх | m2 | 100 |
| | Барилгын нийт талбайд хаявч хийх | m2 | 196 |

Тавигдах шаардлага:

Барилгын ажлыг гүйцэтгэхдээ БНбдүрмийн норм, дүрэм холбогдох бусад журмын заалтыг мөрдлөг болгоно.

Барилгыг чанартай материалаар чанарын өндөр түвшинд технологийн дагуу, чанарын гологдолгүй хийж гүйцэтгэнэ.

Бүх материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн эсхүл орчин үеийн загварын сүүлийн үеийн хандлагыг хангасан байна.

Ажлыг гэрээт хугацаандаа чанарын шаардлагыг хангаж, бүрэн гүйцэтгэх.

Хянасан: ХБС-ын Ерөнхий инженер



Б.Анхбаяр

Гүйцэтгэсэн:

АШҮА-ны ахлах инженер



Б.Энхтуяа

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний өрөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайллан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна. 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |

- | | |
|---|--|
| 9. Зөрчил, гологдол арилгах | <p>9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.</p> <p>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.</p> |
| 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх | <p>10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.</p> |

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- | | |
|---|--|
| 11. Үе шатны ажлын хуваарь | <p>11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.</p> <p>11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.</p> |
| 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх | <p>12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.</p> |
| 13. Алданги | <p>13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.</p> |

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- | | |
|--------------------------|--|
| 14. Ажил дуусгах | <p>14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.</p> |
| 15. Хүлээж авах | <p>15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.</p> |
| 16. Эцсийн тооцоо | <p>16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хургуулнэ.</p> |

Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

- | | |
|--|---|
| 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага | <p>17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.</p> <p>17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.</p> |
| 18. Гэрээг цуцлах | <p>18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.</p> <p>18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none">(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоо тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоо тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;(б) төслийн менежер ажлын явцыг зогсоо зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буудсан;(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон. <p>18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.</p> |
| 19. Гэрээг цуцалсан үед хийх | <p>19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ</p> |

| | |
|-----------------------------------|---|
| төлбөр | мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй. |
| | <p>19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.</p> |
| 20. Гүйцэтгэлээ с чөлөөлөх | <p>20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.</p> |

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

| | |
|-----------------|--|
| ГЕН 2.1 | Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “ ЦДУС/202001012 |
| ГЕН 2.1 | <p>Ажил нь: “Булган дэд станцын авто граж, 10кВ-ын ЗРУ-ын дээврийн засвар Хялганат дэд станцын ОПУ, ЗРУ-ийн барилга, дээврийн засвар Эрдэнэт дэд станцад чийрэгжүүлэлтийн болон ахлах инженерийн өрөө, үүдний хэсэг, дулааны шугам засварлах”</p> <p>Ажлын талбай нь: Орхон аймаг, Хангайн бусийн салбарын Булган дэд станц, Эрдэнэт дэд станц, Хялганат дэд станц.</p> |
| ГЕН 3.1 | <p>Төслийн менежер нь Булган дэд станцын ашиглалтын инженер Б.Батцогоо Эрдэнэт дэд станцын АШҮА-ны дарга М.Бат-Эрдэнэ Хяганат дэд станц АШҮА-ны дарга М.Бат-Эрдэнэ</p> |
| ГЕН 4.1 | <p><u>Зөвшөөрөл авч ажил эхлэсэн өдрөөр тооцогдоно.</u></p> <p>Ажил эхлэх өдөр 2020 оныдугаар сарын-ны өдөр</p> <p>Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2020 оны дугаар сарын-ны өдөр.</p> |
| ГЕН 7.1 | Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдээгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана. |
| ГЕН 9.1 | Чанарын баталгаат хугацаа [365] хоног байна. |
| ГЕН 13.1 | <p>Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0.05% байна.</p> <p>Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 5% байна.</p> |
| ГЕН 17.1 | Гүйцэтгэлийн тайланг гэрээ дүгнэж ажил хүлээлцэхэд гаргаж өгнө |
| ГЕН 19.1 | Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 100%-иар тооцно. |

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

| | |
|-----------------|-----------------|
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |
| (Гарын үсэг) | (Гарын үсэг) |
| (Албан тушаал) | (Албан тушаал) |

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.8.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.9.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]